



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/300

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсгийн харуул хамгаалалт, үйлчилгээний хэсгийн зардалд 1 927 500 төгрөг, бэлэг дурсгалын зүйлсийн зардалд 2 740 000 төгрөг, хүндэтгэлийн арга хэмжээний зардалд 10 106 140 төгрөг, аж ахуйн бэлтгэл болон бусад зардалд 3 317 560 төгрөгийг тус тус хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 18 091 200 төгрөг /Арван найман сая ерөн нэгэн мянга хоёр зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Зах А/300 Ч
02 01531

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар
сарын 10-ны өдрийн А/300 дугаар
захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН
ХОВД АЙМАГТ АЖИЛЛАХ ТӨСӨВ

Д.д	Арга хэмжээний төрөл	Дүн /мян.төг/
1.	Ажлын хэсгийн харуул хамгаалалт, үйлчилгээний хэсгийн зардал	1 927.5
2.	Бэлэг дурсгалын зардал	2 740.0
3.	Хүндэтгэлийн арга хэмжээний зардал	10 106.14
4.	Аж ахуйн бэлтгэл ажлын болон бусад	3 317.56
	ДҮН	18 091.2

-oOo-